

Зарлигуудыг сахидаг тэдний адислагдсан мөн баярт байдал

Үйл ажиллагаа А: “Бурханы зарлигуудыг сахидаг тэдний адислагдсан мөн баярт байдлыг та нар тунгаагаасай. . . . Тэд бүх зүйлд биеийн мөн сүнсний аль алинд нь адислагдсан болой.”

Энэ хичээлийн эхэнд үүсгэсэн адислалынхаа жагсаалтыг хар. Санаандаа орж ирсэн нэмэлт адислалуудыг нэм. Илүү биеийн гэсэн адислалуудын доогуур зурж, илүү сүнслэг гэсэн адислалуудыг дугуйл. Зарим нь энэ хоёр ангилалд багтдаг гэдгийг та ойлгож болох юм.

- Мозая 2:41-д гарч буй эдгээр үгс үнэн гэдгийг харуулах ямар нотолгоо таны амьдралд байгаа вэ?
- Сургаал ба Гэрээ 130:20–21-ийг унш. Та зарлигуудыг сахих, Бурханы адислалуудыг хүлээн авах хоёрын хоорондох уялдаа холбооны талаар юу сурч мэдэж авсан бэ? Та эдгээр шүлгийг Мозая 2:41-тэй холбогдох эшлэл болгож эсвэл холбоос үүсгэхийг хүсэж болох юм.
- Тэнгэрлэг Эцэг яагаад биднийг биеийн болон сүнслэг адислалаар адисалдаг хэмээн бодож байна вэ? Энэ нь Түүний талаар юу зааж байна вэ?

Үйл ажиллагаа Б: “Хэрэв тэд эцсээ хүртэл итгэлтэй байвал тэднийг диваажинд хүлээн авах бөгөөд үүгээрээ тэд Бурхантай хамт хэзээ ч төгсгөшгүй аз жаргалын төлөв байдалд оршиж болно.”

Энэ үгсийг судлах тэмдэглэлийнхээ хоосон хуудасны голд эргэн тойронд нь тэмдэглэл бичих зай үлдээж бич. Өгүүлбэрт буй, таны хувьд ач холбогдолтой үг, хэллэгийг дугуйл. Дугуйлсан үг, хэллэг бүрд тайлбар оруулж, тодорхойлолт, холбогдох судрын хэсгүүд эсвэл өөрт байгаа бусад ойлголтыг бич.

Жишээлбэл: Хэрвээ та “диваажинд хүлээн авах” гэсэн хэллэгийг дугуйлсан бол тайлбарын хэсэгт “хүлээн авах гэдэг нь хэн нэгэн намайг хүлээж байгаа гэсэн үг. Есүс биднийг диваажинд байлгах газар бэлдэж, дараа нь биднийг тэнд хүлээж авах болно хэмээн заасан (Иохан 14:2–3-ыг үзнэ үү). Хайрт Тэнгэрлэг эцэг эх минь, мөн Есүс Христ тэнд байгаа бөгөөд хэрвээ би итгэлтэй хэвээр байвал намайг хүлээж авах болно” гэх мэт зүйлийг оруулж болно.

Дугуйлсан үг эсвэл хэллэг бүрдээ тайлбарын хэсгийг бөглө. Санаандаа орж ирсэн асуулт эсвэл сэтгэгдэлд анхаарлаа хандуул.

- Та энэ үйл ажиллагааг хийж байхдаа ямар ойлголттой болсон бэ?
- Эдгээр ойлголт яг одоо таны амьдралд хэрхэн тус болж байна вэ?

Үйл ажиллагаа В: Ай санагтун, эдгээр зүйлүүд үнэнийг санагтун; учир нь Их Эзэн Бурхан үүнийг ярьсан юм.

- Ямар зүйлсийг санахад амархан байдаг вэ? Ямар зүйлсийг санахад хэцүү байдаг вэ?

Та Мозая 2-ыг судалж байхдаа Бурханы талаар юу сурч мэдсэнээ сана. Мозая 2:22-ыг уншиж, Бурханы талаарх мөнхийн үнэнийг хай.

- Түүний амлалтуудад итгэж, зарлигуудыг сахихад тань туслах Бурханы талаарх ямар зүйлийг та мэдэх вэ?
- Түүний тухай үүнийг санахын тулд та юу хийж чадах вэ?